



НИЙГМИЙН ДЭВШИЛ
ЭМЭГТЭЙЧҮҮД ХӨДӨЛГӨӨН

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ
СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН 7,
8, 9-Р ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ**

ГАРЧИГ

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА.....	3
МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	3
МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ.....	4
МОНИТОРИНГИЙН ДҮН.....	5
ДҮГНЭЛТ	12
ЗӨВЛӨМЖ	13
НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	14
ХАВСРАЛТ 1	16
ХАВСРАЛТ 2	19
ХАВСРАЛТ 3	22

МОНИТОРИНГИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зорилго нь төрийн албан тушаалтны хувийн сонирхол ба албаны сонирхол хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршиж байгаа юм. Хэдийгээр 2012 онд батлагдсан уг хууль төрийн албыг зөвхөн нийтийн ашиг сонирхолд үйлчлэх, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг дээшлүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байгаа ч хэрэгжилтийн түвшинд алдаа оноо байгааг албан тушаалаа урвуулан ашигласан авлигын шинжтэй олон хэргүүд харуулж байна. Мөн АНУ-ын Азийн сан болон Сант марал сангаас хамтарч хийдэг “Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох” 2012 оны судалгаанд оролцогчдын 40.8 хувь нь төрийн албан хаагчид ашиг сонирхлын зөрчилд байнга ордог гэж үзсэн бол 50.7 хувь нь “хааяа ордог” гэж хариулжээ. Энэ бүхнээс харахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсанаар төрийн албыг өөрийн хувийн сонирхолдоо урвуулан ашигладаг явдал төдийлөн буураагүй байна. Тиймээс Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөнөөс уг хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх замаар хэрэгжилт нь сул байхад нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлсэн болно.

Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах хамгийн үр дүнтэй арга нь энэхүү зөрчлөөс урьдчилан сэргийлэх явдал байдаг тул төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас Нээлттэй Нийгэм Форумын Мониторингийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд энэ асуудлыг тусгасан зарим заалтуудын хэрэгжилтэд мониторинг хийлээ.

МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Зорилго: Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг,” “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах” болон “Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх” гэсэн 7, 8, 9-р зүйлийн зарим заалтын хэрэгжилтэд мониторинг хийх.

Зорилтууд:

1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмыг дагуу авах, бүртгэх, хянан шалгах тухай 7.2.2 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
2. Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх тухай 7.2.3 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
3. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх тухай 7.2.5 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
4. Энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна гэсэн 7.3 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх

5. Хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана гэсэн 8.1 дэх заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
6. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй гэсэн 8.2 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
7. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана гэсэн 8.4 дэх заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
8. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ гэсэн 8.6 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
9. Албан тушаалтны энэ хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна гэсэн 8.8 дахь заалтын хэрэгжилтэд мониторинг хийх
10. Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх тухай 9.1 дэх заалтын хэрэгжилтэд мониторинг хийх

МОНИТОРИНГИЙН АРГАЧЛАЛ

Мониторингийг 2013 оны 9-р сарын 1-ээс 2014 оны 1-р сарын 31-ний хооронд өдөр тутам захиргааны акт гаргадаг төрийн байгууллагууд болох мэргэжлийн хяналтын болон татварын байгууллагыг сонгон хэрэгжүүлсэн юм.

Ингэхдээ анхдагч мэдээллийг Улаанбаатар хотын хоёр дүүргийн мэргэжлийн хяналтын газар ба татварын албанаас цуглуулж, шаардлагатай нэмэлт мэдээллийг эдгээр байгууллагуудын дээд шатны хоёр байгууллага болон Авлигатай тэмцэх газраас авч, нийт долоон төрийн байгууллагыг судалгаанд хамруулсан болно.

Мониторингийн асуудлын онцлогийг харгалзан тайланд дурдсан мэдээллийн эх сурвалжийг хамгаалах зорилгоор дээрх байгууллагын нэрсийг А1, А2, А3, Б1, Б2, Б3 гэж кодлож, тайланд тусгалаа. Эдгээрээс А2, А3, Б2, Б3 нь мониторингийн анхдагч мэдээлэл цуглуулсан дүүргийн түвшний байгууллагууд, харин А1, Б1 нь дээд шатны байгууллагууд юм.

Мониторингод хамруулсан хуулийн заалтуудын хэрэгжилтийн талаарх мэдээллийг дараах аргуудыг ашиглан цуглуулсан болно:

1. Баримт бичгийн судалгаа: Ашиг сонирхлын зөрчил, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлсөн байдлыг мэдэгдсэн тохиолдлууд, эдгээрт холбоотойгоор Авлигатай тэмцэх газарт ирүүлсэн мэдээлэл болон мониторингод хамруулсан хуулийн бусад заалтын хэрэгжилтэд хамаарах баримт бичгүүдийг судлахад ашиглав.

2. Ганцаарчилсан ярилцлага: Энэ аргаар байгууллагуудын удирдах албан тушаалтан, Авлигын эсрэг болон Ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулиар байгууллагын түвшинд тусгайлан үүрэг хүлээсэн “эрх бүхий албан тушаалтан” болон холбогдох бусад төрийн албан хаагчдаас мэдээлэл авахад ашигласан юм. Ганцаарчилсан ярилцлагад байгууллагын дотоод бүтэц, алба нэгжийг төлөөлсөн 5 ажилтныг /байгууллага бүрээс 5, нийт 20 албан тушаалтан/-ыг хамруулсан болно.
3. Кейс судлах: Мониторингийн анхдагч мэдээллийг цуглуулсан 4 байгууллага тус бүрээс хяналт шалгалтын чиг үүрэг бүхий 3 албан хаагчийг сонгон авч, тэд захиргааны акт гаргах, хяналт шалгалт хийхдээ ашиг сонирхлын зөрчлийн талаар байгууллагынхаа удирдлагад мэдэгддэг эсэх, удирдлага нь мэдэгдлийг хэрхэн шийдвэрлэж буйг судалсан юм.
4. Сорил, тестийн арга: Мониторингод хамрагдсан байгууллагын албан хаагчдын дунд хуулийн холбогдох заалтуудын талаарх мэдлэг, ерөнхий ойлголтыг тандах цөөн асуулт бүхий тест авсан болно.

Мөн мониторингийн дүнг урьд өмнө өөр байгууллагуудаас хийсэн төрөл бүрийн судалгаа, шинжилгээний дүнтэй харьцуулан тайланд тусгасан болно.

МОНИТОРИНГИЙН ДҮН

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг” буюу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7-р зүйлийн 7.2.2, 7.2.3, 7.2.5 болон 7.3 дэх заалтын хэрэгжилт:

Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2013 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд судалгааны анхдагч мэдээлэл цуглуулсан А2, А3, Б2, Б3 байгууллагын хэмжээнд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5-р тогтоолын 4-р хавсралтаар баталсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийн маягт ашиглан мэдэгдэл гаргасан тохиолдол бүртгэж аваагүй байна. Гэхдээ Б3 байгууллагын нэг албан тушаалтан тухайн ажил үүргийг хэрэгжүүлэхээс татгалзсан тухай гараар бичсэн хүсэлтийг харьяа хэлтэстээ хандан гаргасныг удирдлагын зүгээс шийдвэрлэж байжээ.

7.2.2: Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах.

7.2.3: Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах ажлыг зохион байгуулах, мэдээлэл, мэдэгдлийн дагуу шалгах, хариуцлага хүлээлгэх.

7.2.5: Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх.

7.3: Энэ хуулийн 7.2.2, 7.2.3-т заасан шалгалтын явцад авлигын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулна.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг хүлээн авахын зэрэгцээ төрийн байгууллага, түүний удирдах албан тушаалтан нь ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж

болон бусад эх сурвалжаас хүлээн авах, мэдээллийн дагуу хяналт шалгалт хийж, хариуцлага хүлээлгэх зохицуулалттай юм.

А3 байгууллагын хувьд ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг санал хүсэлтийн хайрцаг, факсаар, цахим хэлбэрээр болон амаар хүлээн авах боломжийг бүрдүүлж ажилласан боловч энэ талаар мэдээлэл хүлээн авч, шийдвэрлээгүй ажээ. Харин А2, Б2, Б3 байгууллагын тухайд 7.2.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл байхгүй байна.

Мониторингийн нэмэлт мэдээлэл цуглуулсан байгууллагуудын нэг болох А1 байгууллага нь хуулийн 7.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлжээ:

- Албан тушаалтантай холбоотой ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах тусгай утас, “Санал хүсэлтийн хайрцаг”-ийг нийслэл, орон нутгийн харьяа албадуудад байрлуулан ажиллуулсан байна. Энэ хүрээнд иргэд, хуулийн этгээдээс утсаар 12, албан бичгээр 24, өргөдөл хүсэлтээр 8, шинэчлэлийн засгийн газрын www.11-11.mn цахим хуудсаар 36, нийт 80 мэдээлэл ирүүлсэнийг хүлээн авч судалж, хариу мэдэгджээ. Мөн холбогдох хэлтэс, тасгийн дарга нарт энэ талаар дуулгаж, ёс зүйн зөрчилгүй, харилцааны доголдолгүй ажиллах талаар сануулж, гомдол гаргасан иргэдэд эргэж хариу мэдэгдсэн байна.
- Дотоод бүтцийн нэгж, аймаг, нийслэл, дүүргүүд дэх харьяа хэлтсийн албан тушаалтнаас ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой 24 өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан бөгөөд тухай бүр хууль журамд нийцүүлэн шийдвэрлүүлж, албан бичгээр хариулжээ.

А1 байгууллагын даргад хаяглагдан ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу дотоод хяналт шалгалт явуулж, тушаалынх нь дагуу 44 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан байна. Үүнд сануулах 14, цалинг тодорхой хувиар бууруулах 13, төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж ажиллах эрхгүйгээр халах 11, албан тушаал бууруулах 3, албанаас халах 3 шийтгэл ногдуулжээ.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил үүссэн тохиолдолд түүнийг арилгах чиглэлээр албан тушаалтанд бичгээр зөвлөмж өгөх тухай 7.2.5 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд А1 байгууллагаас ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 8 албан тушаалтанд бичгээр зөвлөмж хүргүүлж, ашиг сонирхлын зөрчил үүссэн 3 албан тушаалтанд зөрчлийг арилгах талаар албан бичиг явуулжээ. Энэ нь тухайн байгууллагын нийт 1440 орчим ажилтнуудын 0.5 хувьд нь урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, 0.2 хувьд нь ашиг сонирхлын зөрчил үүссэн тул арилгах тухай бичгээр зөвлөмж өгч ажилласан нь ашиг сонирхлын зөрчил гаргасан албан тушаалтнуудын дээрх тоотой харьцуулахад хангалтгүй үзүүлэлт юм.

Албан тушаалтанд хуулийг сурталчлан таниулах, хувийн ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, мэдээллийг хүлээн авах, хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд Авлигатай тэмцэх газар зохион байгуулдаг ажээ. Харин төрийн байгууллагын түвшинд энэ чиг үүргийг байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтан¹ хариуцан ажилладаг юм.

¹ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 сарын 25-ын өдрийн 05 тоот тогтоолын 1-р хавсралтын журмын 3.1-д “Нийтийн албаны удирдлага нь тухайн байгууллагын захиргаа, хуулийн асуудал эрхэлсэн албаны эрх бүхий албан тушаалтанд мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах

Б3 байгууллагын эрх бүхий албан тушаалтантай хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлан таниулах ажлын хүрээнд ямар үйл ажиллагаа явуулж буйг тодруулахад:

Би байгууллагынхаа хуулийн хэлтэст ажилладаг, ажлын шаардлагаар эрх бүхий албан тушаалтны ажлыг үндсэн ажлынхаа хажуугаар давхар гүйцэтгэж байгаа. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн тараах материал, брошур зэргийг ажилтнууддаа тараах хэмжээнд хуулийг таниулах ажил хийж байна. Мөн манай ажилтнуудын зүгээс хуулийн энэ зохицуулалттай холбоотой асуудал гарлаа, мэдээлэл авья гэж орж ирдэггүй. Үндсэн ажлын хажуугаар давхар гүйцэтгэж байгаа учраас хуулийг таниулах чиглэлээр одоогийнхоос илүү цаг зав гаргах боломж байхгүй, ажлын ачаалал их байдаг.

А3 байгууллагаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд авлига болон ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах, хүнд суртал, сөрөг үзэгдлийг хаах зорилгоор холбогдох журмыг үндэслэн 2013 онд 37 албан тушаалтныг сэлгүүлэн ажиллуулжээ.

А2 байгууллагын хувьд 7.2.3, 7.2.5 дахь заалтын хэрэгжилттэй холбоотой аливаа баримт, мэдээлэл хэлтсийн хэмжээнд байхгүй бөгөөд мэдээлэл гаргаж өгөх боломжгүй гэж хариулсан юм. Бусад байгууллагад ч мөн эдгээр заалтад хамаарах мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлига, ашиг сонирхлын зөрчлийн хуулийг таниулах сургалтад мониторингод хамруулсан байгууллагуудын албан тушаалтнууд дунджаар 1-3 удаа хамрагджээ. Ганцаарчилсан ярилцлагын мэдээллээс харахад эдгээр сургалтуудын агуулга нь ихэвчлэн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн гаргахад чиглэсэн, нэг удаагийн сургалтаар их хэмжээний мэдээлэл олгодог, хэт олон оролцогчтой сургалтууд байдаг байна.

2013 оны эхний хагас жилийн байдлаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан бичгийн дагуу А2 байгууллагын хэлтсийн нэр бүхий 2 албан тушаалтантай холбоотой асуудлуудыг хуулийн 7.3 дахь заалтын дагуу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулсан байна. Гэвч тухайн хяналт шалгалтын явцад зөрчил илэрсэн эсэх, илэрсэн бол хуулийн ямар хариуцлага хүлээлгэсэн талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

ажлыг тушаал, шийдвэрээр хариуцуулан томилж, түүнд албан тушаалынх нь цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд уг асуудлыг эрхлэх орон тооны ажилтантай байж болно” гэж заасан байна.

“Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг” буюу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8-р зүйлийн 8.1, 8.2, 8.4, 8.6 болон 8.8 дахь заалтын хэрэгжилт:

Хуулийн 8.1 дэх заалтын дагуу гаргах “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийн маягт”-ыг дээр дурдсан УИХ-ын Хууль Зүйн Байнгын Хорооны 2012 оны 5-р тогтоолын 4-р хавсралтаар баталсан юм.

Судалгааны анхдагч мэдээлэл цуглуулсан дөрвөн байгууллагын хэмжээнд энэ маягтыг ашиглаж ашиг сонирхлын зөрчилгүй болохоо илэрхийлсэн /8.1/ болон ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай /8.2/ мэдэгдэл гаргаагүй байна. Иймд энэ хэсэгт хамаарах заалтууд дээрх байгууллагуудад огт хэрэгжээгүй гэж үзэхэд хүргэж байна.

Хуулийн 8.1 дэх заалтын дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах бүрдээ мэдэгдэл гаргахаар зохицуулсан ч нийт 333 орчим албан тушаалтан ажилладаг эдгээр дөрвөн төрийн байгууллын хэмжээнд мэдэгдэл гаргах маягтыг огт ашиглаагүй, хуулийн энэ зохицуулалтын хэрэгжилтийг харуулах баримт, жишээ хангалтгүй байгаа нь анхаарал татаж байна.

Мониторингод хамрагдсан нийтийн албан тушаалтнуудаас хуулийн 8.2 дахь зохицуулалтыг мэдэх эсэхийг асуухад 10 албан тушаалтан тутмын 3-4 нь энэ талаар тодорхой мэдээлэлгүй байна:


8.1: Хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

8.2: Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

8.4: Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.

8.6: Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

8.8: Албан тушаалтны энэ хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна.



Албан тушаалтнуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын үеэр тэд хуулийн заалтын талаар мэдэхгүй байгаа шалтгааныг дараах байдлаар тайлбарлаж байна:

- Хуулийг таниулах ажил чухал, учир нь мэдэхгүй болон хуулийг ойлгоогүйгээс болоод хэрэглэж чадахгүй байгаа. Мөн хуулийг боловсруулахдаа төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай нийцүүлэх шаардлагатай. Нийтийн албан тушаалтнуудад зориулан гаргасан бол сайн сурталчилж өдөр тутмын ажил үүрэгтэй нь холбож өгөх хэрэгтэй.
- Энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш манай байгууллага дээр мэдэгдэл, тайлбар гаргасан тохиолдол бараг байхгүй. Мэдэгдлийн маягтыг ашигладаггүй. Учир нь нэг ажилтанд ногдох ачаалал маш их учраас энэ талаар бодох ч сөхөө байдаггүй. Дээрээс нь ийм мэдэгдэл гаргадаг талаар бас ийм маягт байдаг талаар мэдэхгүй байна.

Харин тухайн заалтын талаар мэддэг гэж хариулсан албан тушаалтнуудын хувьд хуулийн заалтуудыг өөрийн ажил үүрэгтэй уялдуулан ямар тохиолдолд, хэрхэн ашиглах талаар ур чадвар дутмаг болох нь харагдаж байлаа.

Дээр дурдсанчлан БЗ байгууллагын нэг албан тушаалтан ашиг сонирхлын зөрчил үүссэн тул тухайн ажил үүргээс чөлөөлж өгөх тухай хүсэлтийг гараар бичиж өгч байжээ². Хүсэлтийн агуулгаас харахад асуудал нь хуулийн 8.2 дахь заалтад хамаарч байгаа ч 8.6 дахь заалтыг үндэслэж ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзсан нь өргөдөл гаргагч 8-р зүйлийн заалт хоорондын ялгаа, хэрэглэх нөхцөлийг сайн ойлгоогүйг харуулж байна.

Хүсэлтийг хүлээж авсан удирдах албан тушаалтны гаргасан шийдвэр нь ямар нэг баримт бичгээр баталгаажсан талаар тодорхой мэдээлэл байхгүй бөгөөд удирдах ажилтны амаар гаргасан шийдвэрийн дагуу тухайн ажил үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлсэн байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1 болон 8.2 дахь заалтын хэрэгжилт сул байхад нөлөөлж буй өөр нэг хүчин зүйл бол хуулийн заалт хоорондын уялдаа холбоо, онцлогийг хуулиар бүрэн зохицуулаагүйтэй холбоотой юм. Тухайлбал, 8.1 болон 8.2 дахь заалтын дагуу албан тушаалтан ашиг сонирхлын зөрчилгүй болон ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тухай мэдэгдэх ёстой боловч мэдэгдэл гаргах маягт³ ашиглах тухай зөвхөн 8.1 дэх заалтад дурдаж, 8.2 дахь заалтад энэ талаар дурдаагүй байна. Гэвч маягтын нэр (Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл), агуулгыг нь харахад үүнийг аль аль тохиолдолд хэрэглэх ёстой гэж ойлгогдохуйц байна. Дээрх байдал нь ашиг сонирхлын зөрчил үүссэн ч түүнийгээ хэрхэн мэдэгдэхээ ойлгохгүй байх, цаашлаад зориулалтын маягтыг ашиглахгүй байхад нөлөөлж байна.

² Уг хүсэлтийг хавсралт 3-аас үзнэ үү.

³ Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 4-р сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 4-р хавсралтаар баталсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”

Түүнчлэн, хуулийн 7.2.2-т дурдсанчлан байгууллагын удирдлага, эрх бүхий албан тушаалтан "... ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах"-аар хуульчилсан хэдий ч ашиг сонирхлын зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тухай 8.2 дахь заалтын мэдэгдлийг бүртгэж, хүлээж авах талаар огт дурдаагүй байгаа юм. Энэ нь албан тушаалтан ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тухай мэдэгдлийг заавал хүлээн авч бүртгэх, хянаж шалгахгүй байж болох мэтээр ойлгогдохоор байна.

Мониторингийн судалгааны анхдагч мэдээлэл цуглуулсан дөрвөн төрийн байгууллагад хуулийн 8.6 дахь заалтыг ашигласан, бичгээр тайлбар хийсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Хуулийн 8.8 дахь заалтын хүрээнд албан тушаалтны гаргасан ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдэл, тайлбарыг олон нийтэд нээлттэй байлгаж, танилцах боломжийг нь бүрдүүлж өгсөн билээ. Гэвч төрийн байгууллага хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд мэдэгдэл, тайлбарыг нээлттэй байлгах хуулийн зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэхгүй байна. Хуулийн заалтыг уншихад аль нэг хуулийн этгээдээс хүсэлт гаргах шаардлагагүйгээр мэдээлэлтэй танилцах боломж бүрдсэн байх ёстой гэж ойлгогдохоор байгаа юм. Гэвч мэдээлэл цуглуулах шатанд мониторингийн багийн зүгээс АЗ ба БЗ байгууллагад хүсэлт гаргасны үр дүнд л албан тушаалтнуудын мэдэгдэл, тайлбартай холбоотой мэдээллийг авах боломжтой байсан юм.

Харин А2, Б2 байгууллагуудын хувьд албан тушаалтнуудыг ярилцлагад хамруулах боломж олгосон боловч албан ёсоор мэдэгдэл, тайлбар хүлээн авч бүртгэсэн эсэх талаар баримт, мэдээлэл өгөөгүй юм. Эдгээр байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудын хэлж буйгаар ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл үүссэн тухай тайлбар А2 ба Б2 байгууллагад бүртгэгдээгүй, энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй гэсэн юм. Мэдэгдэл, тайлбар гаргасан тохиолдол байхгүй болохыг эсвэл энэ талаар мэдээлэл өгөх боломжгүйг тайлбарласан албан бичиг өгөх хүсэлтийг А2, Б2 байгууллагад мониторингийн багаас гаргасан хэдий ч албан бичиг өгөөгүй болно.

“Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх” буюу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9-р зүйлийн 9.1 дэх заалтын хэрэгжилт:


Мониторингийн анхдагч мэдээлэл цуглуулсан дөрвөн байгууллагын хэмжээнд албан үүргээ гүйцэтгэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, дарамт шахалт үзүүлсэн тухай мэдээлсэн тохиолдол БЗ байгууллагын хэмжээнд нэг удаа бүртгэгдсэн гэж үзэж болохоор байна. Уг заалтын дагуу хууль бус нөлөөнд өртсөн албан тушаалтан энэ талаар өөрөө мэдэгдэхийг зохицуулсан юм. Харин БЗ байгууллагад бүртгэгдсэн тохиолдлын талаар тодруулахад тус байгууллагын албан тушаалтанд бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад нь дарамт шахалт, зохимжгүй нөлөөлөл үзүүлсэн талаар мэдэж байсан гуравдагч этгээд /хамт ажилладаг хүн/ удирдах албан тушаалтандаа мэдээлж байжээ. Гэвч тухайн мэдээллийг бичгээр өгсөн эсэх, мөн хүлээн авсан удирдах албан тушаалтан уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой мэдээлэл олж чадаагүй болно. Энэ тохиолдол зөвхөн

9.1: Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

тухайн байгууллагын хүрээнд шийдвэрлэгдсэн бөгөөд энэ талаар Авлигатай тэмцэх газарт мэдэгдээгүй байна.

Дээрх тохиолдлоос албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлсөн өөр тохиолдол бүртгэгдээгүй нь нэг талаасаа төрийн байгууллагуудад ийм төрлийн ашиг сонирхлын зөрчил маш бага болохыг харуулах сайн зүйл боловч нөгөө талаасаа огт бүртгэгдэхгүй, бүртгэгдсэн ч ямар хариуцлага хүлээлгэсэн тухай мэдээлэл нь далд хэлбэрт байна уу гэсэн болгоомжлол төрүүлж байна.

Авлигатай тэмцэх газраас 2011 онд хийсэн “Авлигын талаарх олон нийтийн төсөөллийн судалгаа”-нд төрийн албан тушаалтан өөрийн хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх явцад хөндлөнгөөс нөлөөлөх, хууль бус санал тавих тохиолдол 2011 онд улсын хэмжээнд дунджаар 13.1 хувь байгаа юм. Өөрөөр хэлбэл, 10 албан тушаалтан тутмын 1-2 хүнд ийм нөлөөлөл ирдэг болохыг судалгааны дүн харуулж байгаа юм:



Мониторингийн хүрээнд зохион байгуулсан уулзалт, ярилцлагын мэдээлэл мөн дээр дурдсан судалгааны дүнг баталж байна:

Намайг урьд нь нийслэлд ажилладаг байхад манай хуучин даргын зүгээс яг ийм нөлөөлөл, дарамт үзүүлж байсан. Боломжгүй зүйл дээр хятад хүнд ашигтай байдлаар шийдвэр гаргаж өгөхийг хэлтсийн дарга надаас хүссэн. Би энэ асуудлыг бодитой байгаагаар нь шийдвэрлэнэ гэснээс болж бидний хооронд бөөн маргаан болж эцэст нь би өөр ажилд шилжсэн.

БЗ байгууллагын ажилтантай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Хяналт шалгалтын явцад өртэй гарсан байгууллагын дансыг хаах эрх бидэнд олгогдсон байдаг. Уг нь хуулийн дагуу бид харьцангуй өндөр эрх мэдэлтэй л дээ. Жишээ нь, өртэй байгууллагын дансыг хаах тохиолдол гарна. Энэ үед тухайн компаниуд танил талаа ашиглаад дээд албан тушаалтнаар яриулдаг. Ингэхээр хийж байгаа ажил маань ямар ч үнэлэмжгүй болдог. Дарга утасдаад дансыг нь нээчих, удахгүй хийнэ гэж байна гээд л хэлдэг. Иймэрхүү нөлөөлөл байгаа талаар хэлж, яриад эхлэхээр байгууллагадаа ад болдог, ганцаараа үнэнч царайллаа гэсэн яриа, хэл ам гардаг. Аятайхан ажлаа хийгээрэй гэж хүртэл удирдлагаас хэлдэг.

А2 байгууллагын ажилтантай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Хуулийн 9.1 дэх заалтад тусгасан нөлөөллийн талаар албан тушаалтан өөрийн удирдах албан тушаалтнаас гадна эрх бүхий байгууллага⁴ болон Авлигатай тэмцэх газарт мэдэгдэж, шийдвэрлүүлэх боломжтой юм. Гэвч энэ талаар мэдэгдэхгүй байгаа шалтгааныг тодруулахад:

- хууль бус нөлөөллийг хянаж шалгах, шийдвэрлэх эрх бүхий субъект нь өөрөө хууль бус нөлөөлөл үзүүлдэг
- ийм асуудал сөхөөд Авлигатай тэмцэх газарт мэдэгдсэн ч цаг хугацаа болон сэтгэл зүйн хувьд хүндрэл үүсдэг /тус байгууллагаас байнга дууддаг, өөрөө хэрэгтэн юм шиг болчихдог г.м./
- хуулийн дагуу шударгаар шийдвэрлэгдэнэ гэсэн итгэл албан тушаалтнуудад байдаггүй гэсэн шалтгаануудыг нэрлэж байсан юм.

ДҮГНЭЛТ

Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүрэг,” “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах” болон “Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх” гэсэн 7, 8, 9-р зүйлийн мониторингод хамруулсан заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна:

- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллагуудад зохион байгуулж буй ажил учир дутагдалтай байна. Албан тушаалтанд хуулийг сурталчлан таниулах, хувийн ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, мэдээллийг хүлээн авах зэрэг үүрэгтэй “эрх бүхий албан тушаалтан” энэхүү үүргийг өөрийн үндсэн ажилтай хавсран гүйцэтгэж байна. Үүний улмаас ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэрэгжүүлэхээр зохицуулсан дээр дурдсан үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх нөхцөл бүрдэхгүй байна.
- “Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах” тухай хуулийн 8-р зүйлийн талаар нийтийн албан тушаалтнууд мэдэхгүй эсхүл заалт хоорондын зааг ялгаа, хэрэглэх нөхцөлийг сайн ойлгохгүй байгаа улмаас эдгээр заалтууд хэрэгжихгүй байна. Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх асуудлыг хуулиар бүрэн зохицуулж өгөөгүй болон албан хаагчдын өдөр тутмын ажил үүрэгтэй нь холбож хуулийг сурталчлан таниулах чиглэлээр төрийн байгууллагуудын хэмжээнд зохион байгуулж буй ажил хангалтгүй байгаа нь үүнд нөлөөлж байна.

“Албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдэх” тухай 9-р зүйлийн 9.1 дэх заалтад тусгасан хууль бусаар нөлөөлөх тохиолдол мониторингод хамруулсан төрийн байгууллагуудын хэмжээнд нэг л удаа бүртгэгдсэн хэдий ч албан үүргээ гүйцэтгэх явцад дээд албан тушаалтны зүгээс дарамт, шахалт үзүүлэх явдал нэлээдгүй гардаг байна. Хуулийн дагуу зохимжгүй нөлөөллийг бүртгэж, хяналт тавих этгээд нь тухайн ажилтны удирдах албан тушаалтан юм. Хууль бусаар нөлөөлж буй этгээд болон уг асуудлыг хянаж шийдвэрлэх этгээд

⁴ Дээд шатны байгууллага

нэг хүн байгаа нь хуулийн 9.1 дэх заалтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

- Төрийн байгууллага хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд ашиг сонирхлын холбогдолтой мэдэгдэл, тайлбарын талаарх мэдээллийг нээлттэй байлгах хуулийн зохицуулалт нэг мөр хэрэгжихгүй байна. Мэдээлэл өгөх чиг үүрэгтэй албан тушаалд ажиллаж буй ажилтны хувийн үзэл хандлага төдийгүй хуулийн талаарх мэдлэгийн түвшнээс хамаарч мэдээлэл авах хүсэлтийн хариуг өгч байна. Үүнээс гадна, хуулийн 8.8 дахь заалт буюу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн талаарх тайлбар нээлттэй байна гэж зохицуулсан нь учир дутагдалтай юм. Учир нь, 8.2 дахь заалтад тусгасан ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээс татгалзах тухай мэдэгдэл нь нээлттэй байх шаардлагагүй мэт ойлгогдож байна.

ЗӨВЛӨМЖ

Дээрх дүгнэлтэд үндэслэн Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 8 болон 9-р зүйлийн сонгон авсан заалтуудын хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн дараах зөвлөмжийг гаргаж байна:

- Төрийн байгууллагуудад ажиллаж буй эрх бүхий албан тушаалтны албан үүргийг хавсарга байдлаар гүйцэтгүүлэхээс татгалзаж, “эрх бүхий албан тушаалтан”-д хамаарах чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон ажлын байрыг шинээр бий болгох. Энэ хүрээнд эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн хуваарьт уг хуулийг таниулах сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагааг байгууллагын түвшинд болон олон нийтэд /тухайн байгууллагын үйлчилгээг хүртэгч/ хандан зохион байгуулдаг байхаар тусгаж өгөх.
- Хуулийн 7.2.2 дахь заалт болох “хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах” гэснийг “хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, *зөрчил үүссэн* тухай мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах” хэмээн өөрчлөн найруулах.
- Хуулийг таниулах, нэг мөр ойлгож хэрэглэхэд чиглэсэн гарын авлага, сургалтын багц хөтөлбөр боловсруулж, төрийн албан хаагчдыг хамруулах. Ингэхдээ, хуулийг таниулах чиглэлээр төрийн байгууллагад зохион байгуулах сургалт болон соён гэгээрлийн үйл ажиллагааг шинэлэг аргачлалаар, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан зохион байгуулах. Уг үйл ажиллагаанд тухайн чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагыг татан оролцуулж, сургалт болон соён гэгээрлийн чиглэлийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах.
- Уг хуулийг иргэд, аж ахуйн нэгж байгууллага, цаашлаад олон нийтэд таниулах, сурталчлахад чиглэсэн мэдээллийн кампанит ажил зохион байгуулах. Эдгээрт, телевиз болон сониноор дамжуулан сурталчлах, олон нийтийн мэдээллийн сүлжээ хэрэглэгчдийн дунд сонирхолтой, шинэлэг арга хэлбэрээр хуулийг таниулах арга хэмжээг зохион байгуулах.

- Хуулийн 8.2 дахь заалт болох “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй” гэснийг “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл гаргах үүрэгтэй” хэмээн өөрчлөн найруулах.
- Хуулийн 8.1 болон 8.2 дахь заалтаар зохицуулсан ашиг сонирхлын зөрчилгүй болон ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тухай мэдэгдлийг өөр өөр мэдэгдлийн маягтаар гаргадаг болгох.
- Хуулийн 9.1 дэх заалтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор албан тушаалтны албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлсөн явдлын талаарх мэдээлэл хүлээн авдаг, түүнийг шийдвэрлэж, хариуцлага хүлээлгэдэг эрх бүхий субъектүүдийг ялгаатай байдлаар хуульд тусгаж өгөх. Тухайлбал, зохимжгүй нөлөөллийн талаарх мэдээллийг хүлээн авч, хянаж шалгах, хариуцлага хүлээлгэх чиг үүргийг төрийн хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлдэг хараат бус байгууллагад харьяалуулах.
- Хуулийн 8.8 дахь заалт болох “Албан тушаалтны энэ хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна” гэснийг “Албан тушаалтны энэ хуулийн 8.1 мөн 8.2-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна” хэмээн 8.2 дахь заалтад тусгасан мэдээллийг нээлттэй байлгахаар өөрчлөн найруулах.
- Хуулийн 8.8 болон 9.1 дэх заалтуудтай холбоотой мэдээллийг (тухайн тохиолдлуудад ямар арга хэмжээ авч хэрхэн шийдвэрлэсэн, хуулийн ямар хариуцлага хүлээлгэсэн тухай) тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж, албан бичиг болон хүсэлт гаргахгүйгээр нээлттэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх.

НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Мониторингийн дүнд тулгуурлаж боловсруулсан зөвлөмжүүдийг⁵ хууль тогтоох, хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий холбогдох дараах байгууллагуудад захидлаар хүргүүлэхийн зэрэгцээ уулзалтууд зохион байгуулж, судалгааны дүнг танилцуулсан болно. Үүнд:

1. УИХ-ын гишүүн, УИХ-ын Авлигын эсрэг албан бус бүлгийн дарга, Өргөдлийн байнгын хорооны дарга Р.Бурмаа
2. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Бат-Отгон
3. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтан н.Энхнаран
4. Татварын Ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтан н. Заяахишиг

⁵ Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөнөөс хүргүүлсэн зөвлөмжийн төслийг Хавсралт 3-аас үзнэ үү.

Энэ хүрээнд Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахад тухайн байгууллага бүрийн авч хэрэгжүүлэх, анхаарч ажиллах арга хэмжээний талаар ярилцсан юм. Мониторингод хамрагдсан мэргэжлийн хяналт, татварын байгууллагын удирдлагын зүгээс хуулийг албан хаагчиддаа таниулан сурталчлах чиглэлээр илүүтэй анхаарч ажиллахаа мэдэгдсэн бол Авлигатай тэмцэх газраас Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үнэлгээ хийхээ хэлж, үүнд энэхүү мониторингийн дүнг мөн ашиглах болохоо илэрхийлжээ.

ХАВСРАЛТ 1



НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦЫГ ҮНЭЛЭХ НЬ

Нэг. Зорилго

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд болон энэ талаар тайлан боловсруулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичгүүдийг цуглуулах явдал болно.

Хоёр. Зорилтууд

1. Судалгааны мэдээлэл цуглуулахдаа нийслэлийн Сүхбаатар, Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс болон Татварын хэлтсийг хамруулна.
2. Дээрх 2 байгууллагад хийсэн судалгааны дүн нь хуулийн 8 болон 9 дүгээр зүйлийн хэрэгжилтийг үнэлэх үндсэн баримт бичиг болно.
3. Төслийн багийн гишүүд Мэргэжлийн хяналт болон Татварын хэлтсүүдийн удирдах ажилтан, эрх бүхий албан тушаалтан, бусад ажилтнуудтай уулзах, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа удирдамжийн тав дахь хэсэгт буй "Гүйцэтгэх ажлын үндсэн чиглэл"-ийн дагуу ажиллана.
4. Хуулийн сонгосон заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарч буй асуудал, хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулна. Уг зөвлөмж нь нөлөөллийн стратеги боловсруулах суурь болно.

Гурав. Хугацаа

Удирдамжид заасан үйл ажиллагааг 2013 он 09 сарын 23-аас 11 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Баримтлах зарчим

1. Судалгааны ажлыг гүйцэтгэх төслийн баг болон судлаачид нь тус удирдамжид заасан ажлыг гүйцэтгэхдээ төрийн байгууллагуудаас хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүйгээр ажиллана.
2. Судалгааны хүрээнд цуглуулсан мэдээллийг зөвхөн үнэлгээний тайлан боловсруулахад ашиглах бөгөөд байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх үүргийг судлаачид хүлээнэ.

3. Судалгааны мэдээллийг үндэслэн боловсруулах тайланд үнэлгээнд хамрагдсан байгууллагын нэр, ажилтнуудыг тусгайлан кодлон оруулна.
4. Төслийн багийн гишүүд хоорондоо байнга мэдээлэл солилцож хамтран ажиллах ба нэг ижил нэр томьёо, загвар ашиглаж нэгдсэн зохион байгуулалт, ажлын жигд оролцоог хангаж ажиллана.
5. Судалгааны ажлыг удирдамжид заасан хугацаанд хэрэгжүүлж дуусгана.

Тав. Гүйцэтгэх ажлын үндсэн чиглэл

Нийтийн албан нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх аргачлал		
Хугацаа. 2013 оны 10 сарын 01-ээс 11 сарын 15		
Судалгааны респондент ба үйл ажиллагаа	Мэдээллийн агуулга ба аргачлал	Судалгааны ажлыг хариуцан гүйцэтгэх
Нэг. Сүхбаатар болон Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс болон Татварын хэлтсүүдэд ажиллах, мэдээлэл цуглуулах үе шат		
Байгууллагын удирдлага	- Бэлтгэсэн асуултын дагуу ганцаарчилсан ярилцлага хийнэ. - Байгууллагын түвшинд сүүлийн 3 сарын хугацаанд хуулийн холбогдох заалтуудтай холбоотой тохиолдсон 3 кейс тохиолдлыг судлахдаа удирдлагаас мэдээлэл авна.	С.Оюунтуяа А.Мөнхнаран Н.Оюунчимэг Д.Элбэрэл
Эрх бүхий албан тушаалтан	- Бэлтгэсэн асуултын дагуу ганцаарчилсан ярилцлага хийнэ. - Байгууллагын түвшинд сүүлийн 3 сарын хугацаанд хуулийн холбогдох заалтуудтай холбоотой тохиолдсон 3 кейс тохиолдлыг судлахдаа эрх бүхий албан тушаалтнаас мэдээлэл авна.	С.Оюунтуяа А.Мөнхнаран Н.Оюунчимэг Д.Элбэрэл
Төрийн албан хаагчид	Байгууллагын нэгж, хэлтсээс жигд түүвэрлэн 5 албан тушаалтантай уулзаж мэдээлэл цуглуулна. - Хуулийн 8.9 дэх заалтын ойлголт, хэрэглээг тандах зорилгоор урьдчилан боловсруулсан тест авна. - Бэлтгэсэн асуултын дагуу ганцаарчилсан ярилцлага хийнэ.	С.Оюунтуяа А.Мөнхнаран Н.Оюунчимэг Д.Элбэрэл
Хоёр. Сүхбаатар болон Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс болон Татварын хэлтсүүдээр үйлчлүүлэгч иргэн болон байгууллагаас авах мэдээлэл		
Үйлчлүүлэгч иргэд болон байгууллагын төлөөлөл	- Байгууллагаар үйлчлүүлж буй тус бүр 30 иргэнийг анкетын асуулгад хамруулна. - Мөн дээр дурьдсан кейсийн тохиолдлыг шинжлэхдээ холбогдох иргэн болон байгууллагын төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага хийнэ.	С.Оюунтуяа А.Мөнхнаран Н.Оюунчимэг Д.Элбэрэл

Гурав. Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзах, мэдээлэл цуглуулах		
АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс	- Хуулийн 8, 9 дүгээр зүйлийн холбогдох заалтуудад хамаарах асуудлын хүрээнд мэдээлэл авах ажлыг зохион байгуулна.	С.Оюунтуяа А.Мөнхнаран Н.Оюунчимэг Д.Элбэрэл
АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс	- Хуулийн 8, 9 дүгээр зүйлийн холбогдох заалтуудад хамаарах асуудлын хүрээнд мэдээлэл авах ажлыг зохион байгуулна.	С.Оюунтуяа А.Мөнхнаран Н.Оюунчимэг Д.Элбэрэл
Дөрөв. Баримт бичгийн судалгаа /дээрх үе шатуудад цуглуулсан мэдээллийн бүрэн гүйцэд эсэхийг шалгаж нягтлах, уялдаа холбоог гаргах, нэгтгэн дүгнэх зориулалт бүхий/		
Судалгаанд хамрагдсан байгууллага, албан тушаалтнууд	- Ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдэгдэл, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг мэдэгдсэн тохиолдол, эдгээрт хамаарах баримт бичгүүдийг хуулбарлан авч шинжилнэ. - Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдэгдсэн мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалд бичгээр гаргасан тайлбар зэргийн нээлттэй байдалтай холбоотой мэдээллийг гаргуулан шинжлэн судална.	С.Оюунтуяа А.Мөнхнаран Н.Оюунчимэг Д.Элбэрэл

ХАВСРАЛТ 2

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Нэг. Нийтийн албан тушаалтан

Ургийн овог:	Эцэг (эх)-ийн нэр:	Нэр:
Албан тушаал:	Ажиллаж байгаа байгууллага:	
Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр:	Байгууллагын хаяг:	
Албан үүргийн төрөл:	Тайлбар:	

Сонирхлын зөрчилтэй эсэх

Тийм

☐

Үгүй

☐

Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн

албан

тушаалтан

би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

☐

гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

☐

гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

☐

байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

ХАВСРАЛТ 3

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ЗӨВЛӨМЖИЙН ТӨСӨЛ

Нэг. Хуулийг таниулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр:

- Хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, таниулахад чиглэсэн гарын авлага, сургалтын багц хөтөлбөр боловсруулж, төрийн албан хаагчдыг хамруулах.
- Хуулийг таниулах чиглэлээр төрийн байгууллагад зохион байгуулах сургалт болон соён гэгээрлийн үйл ажиллагааг шинэлэг аргачлалаар, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад тулгуурлан зохион байгуулах. Уг үйл ажиллагаанд тухайн чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагыг татан оролцуулж, сургалт болон соён гэгээрлийн чиглэлийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах.
- Төрийн байгууллагуудад ажиллаж буй эрх бүхий албан тушаалтны албан үүргийг хавсарга байдлаар гүйцэтгүүлэхээс татгалзаж, “Эрх бүхий албан тушаалтан”-д хамаарах чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон ажлын байрыг шинээр бий болгох. Ялангуяа Эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн хуваарьт уг хуулийг таниулах, төрийн албаны шударга, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрлийн үйл ажиллагааг байгууллагын түвшинд болон олон нийтэд /тухайн байгууллагын үйлчилгээг хүртэгч/ хандан зохион байгуулдаг байхаар тусгаж өгөх.
- Уг хуулийг иргэд, аж ахуйн нэгж байгууллага, цаашлаад олон нийтэд таниулах, сурталчлахад чиглэсэн мэдээллийн кампанит ажил зохион байгуулах. Эдгээрт, телевиз болон сониноор дамжуулан сурталчлах, олон нийтийн мэдээллийн сүлжээ хэрэглэгчдийн дунд сонирхолтой, шинэлэг арга хэлбэрээр хуулийг таниулах арга хэмжээг зохион байгуулах.
- Мөн хуулийн 8.8 болон 9.1 дэх заалтуудтай холбоотой мэдээллийг (*тухайн тохиолдлуудад ямар арга хэмжээ авч хэрхэн шийдвэрлэсэн, хуулийн ямар хариуцлага хүлээлгэсэн тухай*) тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж, албан бичиг болон хүсэлт гаргахгүйгээр нээлттэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх.

Хоёр. Хуулийн заалтууд хоорондын уялдаа, хамаарлыг сайжруулах чиглэлээр:

- Хуулийн 7.2.2 дахь заалт болох “хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах” гэснийг “*хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах*” хэмээн өөрчлөн найруулах. Учир нь одоогийн заалтын дагуу төрийн байгууллага нь зөвхөн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг хүлээн авч, хянаж шалгах чиг үүрэгтэй мэт харагдаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тухай мэдэгдлийг хүлээн авах үүрэг хүлээгээгүй мэт ойлгогдож болохоор байна.
- Хуулийн 8.1 дэх хэсэгт “...албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг

хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэсэн заалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх. Тухайн шийдвэрийг албан тушаалтан ямар нэг ашиг сонирхлын зөрчилгүй гаргасан гэдгээ баталгаажуулж байгаа энэ зохицуулалтыг 8.2 дахь хэсэгт байгаа ашиг сонирхлын үүссэн тохиолдолтой адилтган хэрэгжүүлж байна. Тиймээс энэ хоёр харилцааг ялган зааглаж, тусдаа өөр өөр мэдэгдлийн маягтаар гаргадаг болгох.

- Хуулийн 8.2 дахь заалт болох “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй” гэснийг “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл гаргах үүрэгтэй” хэмээн өөрчлөн найруулах. Учир нь албан тушаалтан ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд, түүнчлэн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх аль ч тохиолдолд мэдэгдэл гаргахыг хуулиар зохицуулсан хэдий ч зөрчил үүссэн болон үүсч болзошгүй тохиолдолд мэдэгдлээ хэрхэн гаргах тухай тодорхойгүй байгаа юм. Мөн 8.2 дахь заалтын хэрэгжилтийг Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоолын 4-р хавсралтаар дамжуулан сайжруулах боломжтой юм.
- Хуулийн 8.8 дахь заалт болох “Албан тушаалтны энэ хуулийн 8.1-д заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна” гэснийг “Албан тушаалтны энэ хуулийн 8.1, 8.2-д заасан мэдэгдэл болон энэ хуулийн 8.6-д заасан тайлбар нээлттэй байна” хэмээн 8.2 дахь заалтыг нээлттэй байлгахаар өөрчлөн найруулах. Учир нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээс татгалзах тухай мэдэгдэл нь нээлттэй байх шаардлагагүй мэтээр ойлгогдож байна.

Хуулийн 9.1 дэх заалтын хэрэгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх үүднээс албан тушаалтны албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх /хууль бус нөлөөлөл/ байдлын талаарх мэдээлэл хүлээн авдаг, түүнийг шийдвэрлэж, хариуцлага хүлээлгэдэг эрх бүхий субъектүүдийг ялгаатай байдлаар хуульд тусгаж өгөх. Жишээ нь 9.1-д хамаарах нөлөөллийн талаарх мэдээллийг хүлээн авч, хянаж шалгах, хариуцлага хүлээлгэх чиг үүргийг төрийн хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг хараат бус байгууллагад шууд харьяалуулах боломжтой.

ХАВСРАЛТ 3

ТЗД-гэр Мэргэнийн хяналтын
хэлтэс

2015.10.09. нү

ТЗД-гэр Мэргэнийн хяналтын хэлтэсийн нийтийн
хамгааллын хяналтын үеийн байгуулалт Т. Энхтос би
2013 он 09 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн. Т. Охиралын
ирүүлсэн өгөгдөл, гандийн мэдээлэл мэтчилж байгаа.

Энэ нь "Нийтийн албад нийтийн байр хувийн ашиг
сониголын зохицуулалт, ашиг сонирхоос урьдчилан
сэргийлэн худалд" хуулийн 8 дугаар зүйл. "Ашиг сонирхоос
зорилтын мэдээлэл, тайлбар" зүйлийн 8.6 дугаар заагийг
үндэслэн татгалзж байна.

хатгалзсан.

Т. Энхтос

